

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэл -ийн хувь
					Эхний хагас жил		
Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.							
Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.							
1.1.1	БГТ 1.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	5 Удаагийн зөвлөгөө өгөх сургалт арга хэмжээ зохион байгуулсан	Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	2025.04.16-ны өдөр Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нарт 2024 оны нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл болон Хэнтий аймгийн иргэд бусад лавлагаа шатлалын эмнэлэгт тусламж үйлчилгээ авсан статистикийн дагуу судалгаа хийж анхаарах асуудал, цаашид сайжруулах асуудлаар мэдээлэл өгч, хамтран ажилласан. Мөн гэрээ бүхий анхан шатны 25, лавлагаа шатлалын 3 эмнэлэгт тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, хасагдлын мэдээг хүргүүлэн ажилласан.	100
1.1.2	БГТ 1.2.4 Эрүүл мэндийн даатгалын 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.	-	Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо	2024 онд гэрээт ЭМБ-т олгосон санхүүжилтын талаарх статистик мэдээг Хэнтий аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвөлгөөнд танилцуулсан.	Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна	1.2024 он болон 2025 оны эхний улиралд гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтын талаарх статистик мэдээг Хэнтий аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвөлгөөнд оролцсон 68 гэрээт эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт танилцуулсан. Мөн хэлтсийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд түгээсэн. / 5985 дагагч-2025 оны 03 сарын 06 хүртэл / 2.2025 оны эхний улиралд гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийг хэлтсийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд түгээсэн.	100

1.1.3	“Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-	Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ-ийн 2024 оны 05, 06, 14 дүгээр тогтоолыг гэрээт 28 эрүүл мэндийн байгууллагад танилцуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажилласан байна.	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шинэчлэн баталсан 04 дүгээр тогтоолыг танилцуулах, тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх сургалтыг аймгийн нэгдсэн эмнэлэгт 2025.02.14, 2025.04.16-ны өдрүүдэд танхимаар 2 удаа зохион байгуулж, 2025.04.17-ны өдөр гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтнуудад хийж, танилцуулан арга зүйн зөвлөмж өгсөн.	100
1.1.4	ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ 2024 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж байна. Гэрээ бүхий 25 анхан шатны ЭМБ-д хүргэн ажиллалаа.	Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.	ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн 2025 оны 03-р тогтоолыг гэрээт анхан шатны ЭМБ-д хүргүүлж, 2025.02.03-ны өдөр СЭМТ, 2025.01.18, 2025.02.04-ний өдөр ӨЭМТ төвийн ажилнуудад танхимаар 2, цахимаар 1 удаа сургалт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.	100
1.1.5	Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.	-	- Санхүүжүүлсэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо	2024 онд 3728 даатгуулагчийн 630,790,000 төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.	Оны эхний 4 сарын байдлаар эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамрагдсан 18 хүний 2,400,000 төгрөгийн гүйцэтгэл цахим хяналтаар хасагдаж, 1408 даатгуулагчийн 251,110,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. 2025.05.19-ний өдөр мэргэжилтэн У.Энхмэндийн хамт аймгийн нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлгийн төв, дурангийн тасгаар очиж, танилцан, хяналт хийж хамтран ажилласан.	100
1.1.6	ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийж, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг	-	Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт	Тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж Бодлого төлөвлөлтийн	Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан “Нэхэмжлэлийн хяналтын журам”-г шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор 2025.01.17-ны өдөр ирсэн дотоод албан бичгийн дагуур тус журамтай	100

	тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.		хүргүүлсэн саналын тоо	газарт санал хүргүүлсэн.	газарт хүргүүлсэн байна.	холбоотой 9 саналыг хугацаанд нь явуулж ажилласан.	
1.1.7	"ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.		Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо	ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг мөрдөж байна. Гэрээт 38 эмийн санд журмыг хүргүүлэн хяналт тавин ажилласан.	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна.	2025 оны 01 сарын 16-ны өдөр Хэнтий аймгийн гэрээ бүхий 38 эмийн сангийн эрхлэгч, эм зүйч нарт 2024 оны хөнгөлөлттэй эм олголт, анхаарах асуудал сэдвээр танхимын сургалт хийж, "ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-ний жагсаалтыг дахин танилцуулсан.	100
Зорилт 1.4. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно:							
1.2.1	<i>БСТ 2.1.3, БГТ-1.4.3</i> Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.	-	Хүргүүлсэн саналын тоо	Нийт 2 удаа тогтоолын төсөлд санал хүргүүлсэн.	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	Нэхэмжлэлийн хяналтын журамд 2025 оны 01 сарын 20-ны өдөр, Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хамтын гэрээнд 2025 оны 05 сарын 06-ны өдөр, Улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэрэгийн нэмэгдэл олгох журамын төсөлд 2025 оны 04 сарын 09-ний өдөр тус тус саналыг хүргүүлсэн.	100
1.2.2	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.	-	Зөрчлийн хэргийн тоо Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн	3 зөрчлийн хэргийн 32,7 сая төгрөгийг ЭМД санд төвлөрүүлсэн.	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	Засгийн газрын 1111 төвд иргэн Л.Наранцацралын гаргасан гомдлын дагуу ЭМДЕГазрын даргын 2025.05.14-ны өдрийн "Албан томилолтоор ажиллуулах тухай" А65 тоот тушаалаар эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч Д.Оюунбадам 2025.05.16-ны өдөр Норовлин сумын "Улз тун" ХХКомпаний эмийн санд газар дээрхи хяналтыг хийж, 2,9911,600 төгрөгийн зөрчилд зөрчлийн хэрэг үүсгэн хялбаршуулсан журмаар хянан шалгаж, шийдвэрлэн холбогдох баримт бичгийг аймгийн Прокурорын газарт хүлээлгэн өгсөн.	100

Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.							
Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.							
2.1.1	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГУАХ 2.1.7, БГТ 2.1.1 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна	-	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 42,0.	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2025 онд 75%.	1114 малчин эрүүл мэндийн даатгалд хамрагдаж 4 сарын байдлаар хамрагдалт 52 хувьтай байна. 1009 оюутан эрүүл мэндийн даатгалд хамрагдаж 4 сарын байдлаар хамрагдалт 347 хувьтай байна. 729 тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд ЭМДаатгалд хамрагдаж 4 сарын байдлаар 50 хувьтай байна. 21 гадаадын иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаж 242 хувьтай байна Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын 100 хувь	74
			Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 100,0	Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2025 онд 100%.		
			Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 34,0.	Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2025 онд 75%.		
			-Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 50,0	Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2025 онд 75%.		
2.1.2	БСТ -2.1.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн авлагыг хууль хяналтын байгууллагатай хамтран шийдвэрлүүлнэ.	-	Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн	2024 онд 23 иргэний 13,8 сая төгрөг төвлөрүүлсэн..	УДШ-ийн шийдвэрийн хэрэгжилт, ЭМДҮЗ-ийн 2021 оны 11 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан байна.	1. 2025 оны эхний 4 сарын байдлаар Хэнтий аймгийн Прокурорын газарт гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон 40 иргэний, Бор-Өндөр сумын Прокурорын хэлтэст 8 иргэний эрүүл мэндийн байгууллагаас авсан тусламж, үйлчилгээний зардлыг нэхэмжилсэн. 2. Аймгийн цагдаагийн газарт гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон 22 иргэнд холбогдох хэрэгт иргэний нэхэмжлэгчээр оролцож, холбогдох баримт бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар хүргүүлсэн.	100

						3. 2025 оны эхний улиралд гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон 6 иргэний эрүүл мэндийн даатгалын санд учруулсан 6,596,519 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн. 4. 2025.04.22-ны өдөр Хэнтий аймгийн Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх тасаг, Мөрдөн байцаах тасгийн нийт албан хаагчдад Гэмт хэргийн улмаас Эрүүл мэндийн даатгалын санд учруулсан хохирлыг нөхөн барагдуулах талаар мэдээлэл чиглэл өгч ажилласан.	
2.1.3	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.	-	Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	Санхүүгийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна.	Гэрээ бүхий 68 эрүүл мэндийн байгууллагын Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцсийн зардлын тайланг тогтоосон хугацаанд цахим болон цаасан хэлбэрээр гарган гарын үсэг зурж тамга даран баталгаажуулан Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.	100
2.1.4	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.		Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2024 оны орлогын төлөвлөгөөний биелэлт 88 хувьтай байна.	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	1.Ажил олгогчийн даатгуулагчийн шимтгэл 4,245,798,443 мянган төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 83 хувь 2.Оны эхний 4 сарын байдлаар шимтгэлээ өөрөө төлдөг 2873 иргэний 366,673,960 төгрөгийн шимтгэл төлөгдөж, төлөвлөгөө 74 хувиар биелэсэн байна. Үүнээс: 1114 малчны 138,245,720 төгрөгийн, тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй 729 иргэний 104,554,760 төгрөгийн, 1009 оюутан суралцагчийн 119,750,240 төгрөгийн, гадаадын иргэн харьяалалгүй 21 иргэний 4,123,240 төгрөгийн шимтгэл төлөгдсөн байна.	83,3
Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална.							
2.2.1	БСТ 2.2.1, БГТ-2.2.1 Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.	ЭМДС	Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан	Гэрээт 66 ЭМБ-д 3,4 тэрбум төгрөгний өглөгтэй гарсан тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна	2024 оны жилийн эцсийн тайлангаар гэрээ бүхий 67 эрүүл мэндийн байгууллагад олгох 3,4 тэрбум төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулсан.	100
Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна							

Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.							
3.1.1	БСТ 3.1.2, БГТ 3.1.1 Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.	-	Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо	68 гэрээт эрүүл мэндийн байгууллагыг дүгнэсэн.	Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй.	2024 онд гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллага 69. Үүнээс 68 эрүүл мэндийн байгууллагын гэрээг бүрэн дүгнэж, тогтоосон хугацаанд нь Худалдан авалт гэрээлэлтийн газарт, саналын хамт хүргүүлсэн. Мөрөн сумын Их мөрөн шүүдэргэнэ эмийн сан өөрийн хүсэлтээр гэрээ цуцлагдсан.	100
			Гэрээний хэрэгжилтийн хувь	Гэрээний хэрэгжилт 89,7 хувь		2024 оны гэрээний хэрэгжилт анхан шатны эрүүл мэндийн байгууллагад -77,3 хувь, лавлагаа шатлалын эмнэлэгт- 76,0 хувь, сувилалд- 99,8 хувь, эмийн сангуудад 97,6 хувьтай байна.	87,6
3.1.2	2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Өрхийн ЭМТ-4, Сумын ЭМТ-21, Эмийн сан-38	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.	2025.01.16-ны өдөр 38 эмийн санд танхимын сургалтыг хийж, гэрээг байгуулсан. Лавлагаа шатлалын 3 эмнэлэг, 2 сувилалтай 2025 оны төсвийн хэлцлийг хийж, гэрээг тоон гарын үсгээр баталгаажуулан, хугацаанд нь ХАГГазарт хүргүүлсэн. Анхан шатны 25 эрүүл мэндийн байгууллагад 2025 оны төсвийг урьдчилж хүргүүлэн, сар бүрийн хуваарийг гаргуулан авч, гэрээ болон хавсралтыг баталгаажуулан хугацаанд нь ХАГГазарт хүргүүлэн ажилласан.	100
3.1.3	Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.		Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан	Лавлагаа шатлалын гэрээт 5 байгууллагыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан	Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	1.Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад цахим сургалтыг хийсэн. 2. Гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын болон нягтлан бодогч нарын группт нэхэмжлэлийн хяналтын журам болон шинэчлэн батлагдсан тогтоолыг 7 хоногт 2 удаа хэсэгчлэн байршуулж мэдээллээр тогтмол ханган, тухай бүр асуултад хариулж арга зүйн зөвлөмж өгч ажиллаж байна.	100

Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна							
3.2.1	БГТ 3.2.1 Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.	Э М Д С	Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн,,	Нийт давхардсан тоогоор 68 эрүүл мэндийн байгууллага, 394138 хүнд 42,1 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан.	Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	1.2025 оны эхний 4 сард давхардсан тоогоор лавлагаа шатлалын 295 эрүүл мэндийн байгууллагын 11239 түүвэрлэгдсэн баримтад нэхэмжлэлийн нарийвчилсан хяналт хийж, 1449 хүний 444,254,881 төгрөгийн хасалт хийсэн байна. 2. Анхан шатны 25 эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт хийж 951 хүний 132,972,604 төгрөгийн хасалт хийсэн байна. 3. Гэрээт 38 эмийн санд эхний 4 сарын байдлаар 24,241 хүний 797,845,627 төгрөгийн санхүүжилт олгосон. 4. 2025 оын эхний 3 сарын байдлаар Хэнтий аймгийн гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад 19,043 хүний 1,805,359,278 төгрөгийн санхүүжилтыг олгосон байна 5. Аймгийн нэгдсэн эмнэлгийн 452 хүний 25,542,732 төгрөгийн Төр хариуцах эмийн санхүүжилтийг олгосон. 6. Эрт илрүүлгийн 1408 иргэний 251,110,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон. 7. Рашаан сувилалд 30 иргэний 8,190,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон.	100
3.2.2	БГТ 3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	-	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2024 онд 68 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.	3 лавлагаа шатлалын эмнэлэг, 25 өрх, сумын эрүүл мэндийн төвд 2025 оны 1-р улирлын тусламж, үйлчилгээний гүйцэтгэл хянасан мэдээг хүргүүлж, хяналтаар хасагдсан шалтгааныг хүргүүлэн ажилласан.	100
3.2.3	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.	-	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	Эрүүл мэндийн даатгалын улсын ахлах байцаагчийн 35 зөвлөмж, улсын байцаагчийн 5 зөвлөмж нийт 40 зөвлөмжийг хүргүүлсэн.	Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Хэнтий аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын баталсан 2025.03.13-ны өдрийн 10-34-07/01 тоот удирдамжийн дагуу Ач манал өрхийн эрүүл мэндийн төвд газар дээрх хяналт хийж, оношилгоо шинжилгээний тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг шалган, эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан.	100

3.2.4	<p><i>БСТ 3.2.3, БГТ-3.2.2</i> Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.</p>	-	<p>Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо Хяналт, шалгалтын тайлан</p>	<p>2024 онд 21 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт, шалгалт хийж нэгдсэн тайлан гарсан.</p>	<p>Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.</p>	<p>1. Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Ач манал өрхийн эрүүл мэндийн төвд 2025.03.13-ны өдөр газар дээрх хяналт хийж, оношилгоо шинжилгээний тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг шалган, улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн ажилласан. 2.ЭМДЕГазрын даргын “Албан томилолтоор ажиллуулах тухай” 2025.04.14-ний өдрийн А/47 тушаалын дагуу 2025.04.16-ны өдөр хэлтсийн дарга С.Хэнчмэдэхгүй, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн Ц.Энхзулын хамт Батноров сумын ЭМТөвд газар дээрх хяналт хийж, хэвтүүлэн эмчлэх үед хийгдсэн оношилгоо шинжилгээг ЭМД сангаас давхар нэхэмжилсэн байсан тул 2025 оны 02 дугаар сарын 35 иргэний 864,000 төгрөгийг хяналтын үед хасч тооцсон ба 2025 оны 03 дугаар сарын 18 иргэний 349,000 төгрөгийн гүйцэтгэлийг мөн хяналтаар хасч, 2025 оны 1 дүгээр сарын 11 хүний 310,000 төгрөгийн нэхэмжлэлд Эрүүл мэндийн даатгалын улсын ахлах байцаагчийн акт тавихаар шийдвэрлэлээ. 3.ЭМДЕГазрын даргын 2025.05.14-ны өдрийн “Албан томилолтоор ажиллуулах тухай” А65 тоот тушаалын дагуу чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн Д.Оюунбадам 2025.05.16-ны өдөр Норовлин сумын “Улз тун” ХХКомпаний эмийн санд газар дээрхи хяналтыг хийж, Засгийн газрын 1111 төвд гомдол гаргасан иргэн Л.Наранцацралтай уулзаж мэдүүлэг авч ажилласан. Улз тун эмийн санд зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэв.</p>	100
<p>Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.</p>							

Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө.							
4.1.1	ЗГҮАХ-2.1.9, БГТ 4.1.3 Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ.	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан	4 арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.	Орон нутгийн удирдлагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.	1.Хэнтий аймгийн ЗДТГазраас төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж буй “Асуудлаас шийдэлд” арга хэмжээний хүрээнд мэргэжилтэн У.Энхмэндэд гэр бүлийн хэрэгцээний газрын асуудлыг шийдүүлэн 2025 оны эхний улиарлд газрын гэрчилгээтэй болгосон. 3. Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан сургалтад 5, олон нийтийн арга хэмжээнд 3, агентлагын дарга нарын шуурхайд 6 , тусгай зөвшөөрлийн хуралд 3, ТУЗ-ын хуралд 2, Аймгийн ИТХуралд 2 удаа оролцсон. 4. Хэлтсийн үйл ажиллагаатай холбоотойгоор орон нутгаас дэмжлэг хүсч аймгийн засаг даргад Ухаалаг дэлгэцээр хангаж өгөх хүсэлт гаргасан. 5. Аймгийн засаг даргад 3, аймгийн ИТХурлын даргад 1, НБХэлтсийн даргад 2, Хэрлэн сумын засаг даргад 1 удаа хэлтсийн ажлаа танилцуулж мэдээллээр хангасан. 6. Хэнтий аймгийн Эрүүл мэндийн салбарын 100 жилийн ойн урлагын тоглолтод хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай баг болж оролцсон.	100
4.1.2	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо	Зохион байгуулсан арга хэмжээ-9.	Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.	1.2025 оны 1 сарын 23-ны өдөр Баянхутаг сумын иргэд болон эмнэлгийн ажилчдад Эрүүл мэндийн даатгалын тухай ойлголт, мэдлэг боловсролыг дээшлүүлэх цахим үйлчилгээг таниулах өдөрлөгт оролцож ЭМДҮЗ-ийн шинээр болон шинэчлэн баталсан тогтоол, холбогдох хууль журмуудыг танилцуулсан. 128 хүн хамрагдсан. 2.2025 оны 4 сарын 04,09-ний өдрүүдэд Хэнтий аймгийн Хэрлэн сумын засаг даргын тамгын газрын албан хаагчид болон Голомт банкны ажилчдад Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, хэрхэн шалгах, төлөх талаарх сургалт хийж мэдээлэл арга	100

						зүйгээр хангаж ажилласан. 42 ажилтан хамрагдсан. 3.2025 оны 4 сарын 24-ний өдөр Өлзийт тосгонд Эрүүл мэндийн даатгал сурталчлах өдөрлөг зохион байгуулж 52 иргэн хамрагдсан.	
4.1.3	Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.	-	Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо	Албан ёсны цахим хаягуудаар нийт 166 контент бэлтгэн, түгээсэн. Хэлтсийн цахим хуудсаар 630 мэдээг иргэдэд түгээж дагагчийн тоо 5709 хүрсэн.	6000 иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна.	1.2025 оны 03 сарын 06 хүртэл ажиллуулж байсан цахим хуудасны дагагчийн тоо 5978 болж Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бэлтгэсэн 662 мэдээ, өөрийн хэлтсийн бэлтгэсэн 171 цаг үеийн мэдээ болон контентыг сум бүрийн групп болон гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын пейж хуудсаар дамжуулан иргэдэд түгээж мэдээллээр хангаж ажилласан. Өмнөх пэйж хуудсыг Facebook программ түр хугацаанд хаасан байгаа тул 2025 онд шинэ пэйж хуудас нээн ажиллуулж эхлээд байна. 2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бэлтгэсэн 258 мэдээг хэлтсийн цахим хуудсаар дамжуулж олон нийтэд түгээсэн. 3. 68 контент бэлтгэн хэлтсийн пэйжд түгээсэн, сум бүрийн групп болон гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын пейж хуудсаар дамжуулан иргэдэд түгээлгэж байна.	100
4.1.4	<i>БГТ 4.1.8</i> Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.	-	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	Судалгаанд нийт 169 мэндийн байгууллага хамрагдан, үр дүнг тооцсон..	Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	1.Олон нийттэй харилцах хэлтсээс ирүүлсэн сэтгэл ханамжийн QR судалгааг гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын групп болон хэлтсийн пэйж хуудсанд нээлттэй байршуулсан. 2. Хэлтсийн үйл ажиллагааг үнэлэх сэтгэл ханамжийн судалгаанд Хэнтий аймгийн эрүүл мэндийн салбарын 76 ажилтан хамрагдсан. 3. Судалгааны дүнтэй хэлтсийн албан хаагчид танилцаж, цаашид анхаарах асуудлаа хэлэлцсэн.	100

4.1.5	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.	-	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	Өргөдөл гомдол-778, шийдвэрлэсэн-747, шилжүүлсэн-31 шийдвэрлэлт 100 хувь	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	1.Эхний 4 сарын байдлаар ирсэн бичиг цаасаар -15, ег-имонгол цахимаар ирсэн албан бичиг-109, явсан бичиг-69, хугацаа хоцроосон, шийдвэрлээгүй албан бичиг байхгүй. 2. Ирсэн дотоод албан бичиг-17, явсан дотоод албан бичиг-15 3. Засгийн газрын 1111 төвд гаргасан өргөдөл-3 бүгд шийдвэрлэсэн. Бор-Өндөр сумын 2 иргэнтэй холбогдож асуудлыг тайлбарлан, өөрсдөөр нь тайлбар гаргуулан авч өргөдлийг хаасан. Норовлин сумын иргэний гаргасан өргөдлийн дагуу газар дээрхи хяналт хийж, гэрээ бүхий эмийн санд зөрчлийн хэрэг нээн шийдвэрлэсэн.	100
4.1.6	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллана.	-	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 17 удаа гаргаж хэрэгжилт 100 хувь. Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтийн хангаж тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	Удирдлагын шуурхай хуралдаанаас орон нутгийн хэлтэст үүрэг болгосон даалгаврыг хугацаанд тогтмол хийж гүйцэтгэж, тайланг 15 удаа хүргүүлэн	100
4.1.7	Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон хэлтсийн дотооддоо хийж гүйцэтгэсэн ажлуудын хэрэгжилтийг хангаж биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнана.	-	Үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь	-	Үүрэг даалгаврыг биелэлтийг хугацаанд нь хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1.Хэлтсийн 2025 оны эхний улирлын бичмэл тайланг хугацаанд нь хүргүүлсэн. 2. Нэхэмжлэлийн хяналтын 1-р улирлын тайланг НХХэлтэст 2025.03.31, Улсын байцаагчийн тайланг Тамгын газарт 2025.04.01, Сумын эрүүл мэндийн төвийн шүдний кабинетийн судалгааг 2025.04.15, төр хариуцах эмийн 2024 оны судалгааг 2025.04.16, 2024 оны гэрээ дүгнэсэн нэгтгэл,тайланг ДАХШҮГазарт 2025.05.12, аймгийн нэгдсэн эмнэлэг болон лавлагаа шатлалын эмнэлгийн төрөлтийн түүхийг нэхэмжлэлийн хяналтын хэлтэст 2025.03.28-ны өдөр хүргүүлсэн. Анхан шатны эрүүл мэндийн санхүүжилтийн сарын төсвийн	100

						хуваарийн саналыг авч нэгтгэн ХАГТ 2025.05.20-ны өдөр хүргүүлсэн.	
4.1.8	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.		Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний	Хэлтсийн мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан	Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.	1.Хэлтсийн 3 албан хаагчтай 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллаа. 2.Албан хаагч тус бүрт албан тушаалын тодорхойлолтын дагуу ажил үүргийг тэнцүүлэн хуваарилж гарын үсгээр баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавин удирдлагаар ханган ажиллаж байна. 3. Ажлын цаг ашиглалтад хяналт тавьж хэрэгжүүлэн ажилласан.	100
4.1.9	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө.	-	Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо	2024 оны архивын нэгжийг бүрдүүлж, албан бичиг хөтлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөн 2024 оны 26, 2025 оны эхний улирлын 3 боть баримтыг архивын нэгж болгон бүрдүүлж, цэгцлэн архивт хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон.	100
4.1.10	Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна.	-	-Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо - Хэрэгжилтийн хувь	-	Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.	Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэлтсийн албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулж хэвшсэн.Үүнд: егр-имонгол цахимаар 38, авле-ээр 31 албан бичгийг монгол бичгээр явуулсан.	100
4.1.11	Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ.	-	Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо	-	Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим	1.Хэлтсийн явсан 31 албан бичгийг цахим гарын үсгээр баталгаажуулан, ДОСХ программ ашиглан цахимаар холбогдох албан байгууллагуудад илгээж хэвшсэн. 2. Хэлтсийн 3 мэргэжилтэн АВЛЕ системд албан бичиг төлөвлөн, цахимаар илгээж сурсан.	100

					гарын үсэг нэвтрүүлсэн байна.		
4.1.1 2	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана	-	Хэрэгжилтийн хувь		ЭМДЕГ-аас гаргасан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1.Хэлтсийн 4 албан хаагчид хуулийн хугацаандаа ХАСХОМ бөглөж хүргүүлсэн. 2. 2025 оны 01 сарын 16-17-ны өдөр Авилгын эсрэг хууль тогтоомжийн сургалтад албан хаагчид бүрэн хамрагдсан. 3. Авилгын эсрэг контентыг Хэнтий аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн пэйж хуудсанд 5 удаа түгээлээ.	100
Зорилго 5: Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлнэ							
5.1	Эрүүл мэндийн даатгалын шинэчлэгдсэн тогтоол шийдвэрүүдийг тухай бүр нь судалж, танилцан бүрэн мэдлэгтэй болно.		Шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх	-	Сургалтад бүрэн хамрагдсан байна.	1.2025 онд шинэчлэн батлагдсан тогтоол болон нэхэмжлэлийн хяналтын журмыг хэвлэж хавтаслан, албан хэрэгцээнд тогтмол ашиглаж байна. 2. Ерөнхий газраас зохион байгуулсан тогтоол, шийдвэрийн сургалтад бүрэн хамрагдлаа.	100
5.2	БГТ 4.1.4 Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана.	-	Хамрагдсан сургалтын тоо	ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан.	Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан мэдээллийн цаг сургалтад 15 удаа, төрийн албаны зөвлөлийн сургалтад 1 удаа, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 04, 03 тогтоолыг танилцуулах сургалтад 2 удаа хэлтсийн албан хаагчид цахимаар бүрэн хамрагдсан байна.	100
5.3	Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, үр чадвараа дээшлүүлнэ.		Хамрагдсан сургалтын тоо	Нийт 18 удаагийн сургалтад оролцсон.	Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна.	1.2025 оны 54 сарын 01-02-ны өдрүүдэд Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан зүүн бүсийн төрийн албан хаагчдын "Төрийн албаны МАНЛАЙЛАЛ", төрийн албаны ёс зүй, төрийн албаны шинэчлэл сэдэвт салбар хорооны сургалтад 4 албан хаагч хамрагдлаа. 2. Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг таниулах, мэдээлэл, аргазүйн удирдлагаар хангах, үр дүн, туршлагыг	100

						нэвтрүүлэх талаарх цахим сургалтанд бүрэн хамрагдсан.	
5.4	Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах	-	Хамрагдсан сургалтын тоо	-	Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилж, Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна.	1.Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн У.Энхмэнд Монгол бичгийн сургалтад хамрагдсан. 2. Хэлтсийн албан хаагчид өөрсдийн боловсруулсан албан бичгийг монгол бичгээр хөрвүүлж, мэдлэг чадвараа дээшлүүлэн ажиллаж байна. 3. Монгол бичгийн хэрэглээ, түүний ач холбогдол сэдэвт сургалтад 2025 оны 04 сарын 02-ны өдөр хамрагдсан.	100

Төлөвлөгөөг үнэлсэн:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн:
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Тайлагнасан:
ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)



Төсвийн шууд захирагч

(С.ЭНХБОЛД)

(огноо)

Нэгжийн дарга

(Б.ОЮУНЦЭЦЭГ)

(огноо)

2025.06.24

Нэгжийн дарга

(С.ХЭНЧМЭДЭХГҮЙ)

(огноо)

2025.05.23